

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ БААТАР ОВОГТОЙ БЯМБАЦОГТЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
НЭГ. "ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ДЭД БҮТЭЦ, ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, үр дүн.	Хэрэгжилт гүйцэтгэлээр		Эхний хагас жил: Тайлант хугацаанд төлөвлөсөн худалдан авах ажиллагааг хугацаанд нь ил тод нээлттэй зохион байгуулж, өглөг, авлага үүсгэлгүй ажилласан байна.	<u>Гаалийн байгууллагын бараа, ажил үйлчилгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт:</u> Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуулиар гаалийн ерөнхий газрын хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд 11,270.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдэхээр батлагдсан. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах тоног төхөөрөмжийн нэр төрөл, тоо хэмжээг ГЕГ-ын Захиргааны зөвлөлийн хуралдааны 2025 оын 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01 дүгээр шийдвэрээр баталгаажуулсан. Уг шийдвэрийн дагуу ГЕГ-ын 2025 оын 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/02 тушаалаар 2025 оны төсвийн тухай	2025.01.01-2025.06.10	100

хуулийн 2 дугаар хасвралтаар батлагдсан ГЕГ-ын 2025 онд санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тоног төхөөрөмжийн жагсаалтыг батлуулсан.

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 233 дугаар тогтоолын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газарт худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлэх албан бичгийг худалдан авах тоног төхөөрөмжийн жагсаалт, техникийн үзүүлэлтийн хамт ГЕГ-ын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01/100 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Төрийн худалдан авах ажиллагааны газраас тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж дараах аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулах зөвлөмжийг ирүүлсэн. Үүнд:

1. Гаалийн мэдээлэл технологи, цахимжуулалтын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ **2,720.0 сая төгрөг;**

1.1. ТХААГ-аас ГЕГ-т зөвлөмж ирүүлсний дагуу 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр “Саммит компьютер технологи” ХХК-тай 2,499.0 сая төгрөгөөр гэрээг байгуулсан. Гэрээний дагуу тоног төхөөрөмжийг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр тоног төхөөрөмжийг бүрэн хүлээн авсан бөгөөд гүйцэтгэгчид санхүүжилтийг олгоход бэлэн болсон.

2. Гаалийн хяналтын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ **8,550.0 сая төгрөг;** Уг

				худалдан авах ажиллагааг 7 багц болгон тендрийг зохион байгуулсан бөгөөд 6 багцад гүйцэтгэгч шалгаран гэрээг байгуулсан. 2.1. Багц-1 – ТХААГ-аас ГЕГ-т зөвлөмж ирүүлсний дагуу “Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис илрүүлэх тандагч багаж” нийлүүлэх гэрээг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр “Цэцүүх трейд” ХХК-тай 1,186.0 сая төгрөгөөр байгуулсан. Гэрээний дагуу тоног төхөөрөмжийг 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн дотор хүлээлгэн өгнө. 2.2. Багц-2 – ТХААГ-аас ГЕГ-т зөвлөмж ирүүлсний дагуу “Ачаа тээш шалгах рентген тоног төхөөрөмж” нийлүүлэх гэрээг 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр БНХАУ-ын “Nuctech Company Limited” компанитай 4,755.9 сая төгрөгөөр байгуулсан. Гэрээний дагуу тоног төхөөрөмжийг 2025 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүлээлгэн өгнө. 2.3. Багц-3 – Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2 дахь хэсэгт заасны дагуу гүйцэтгэгч шалгараагүй тендерийн Багц-3 буюу “Бараа ачиж буулгах – Сэрээт ачигч” худалдан авах 540 сая төгрөг хэмнэлтэд тооцогдсон. 2.4. Багц-4 – ТХААГ-аас ГЕГ-т зөвлөмж ирүүлсний дагуу “Ачаа тээш шалгах рентген тоног төхөөрөмж” нийлүүлэх гэрээг 2025 оны 04 дүгээр		
--	--	--	--	---	--	--

					сарын 23-ны өдөр БНХАУ-ын "Nuctech Company Limited" компанитай 4,755.9 сая төгрөгөөр байгуулсан. Гэрээний дагуу тоног төхөөрөмжийг 2025 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүлээлгэн өгнө. 2.5. Багц-5 – ТХААГ-аас ГЕГ-т зөвлөмж ирүүлсний дагуу "Телехяналтын тоног төхөөрөмж" нийлүүлэх гэрээг 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр "Тотал технологи" компанитай 409.7 сая төгрөгөөр байгуулсан. Гэрээний дагуу тоног төхөөрөмжийг 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр хүлээлгэн өгсөн. Телехяналтын тоног төхөөрөмжийн суурилуулалтын ажил хийгдэж байна. 2.6. Багц-6 – ТХААГ-аас ГЕГ-т зөвлөмж ирүүлсний дагуу "Гаалийн хяналт шалгалтын байцаагч нарын компьютер" нийлүүлэх гэрээг 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр "Бодь-Электроникс" компанитай 464.0 сая төгрөгөөр байгуулсан. Гэрээний дагуу тоног төхөөрөмжийг 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр компьютерийг бүрэн хүлээн авсан бөгөөд гүйцэтгэгчид санхүүжилтийг олгоход бэлэн болсон. 2.7. Багц-7 – ТХААГ-аас ГЕГ-т зөвлөмж ирүүлсний дагуу "Хүнсний бүтээгдэхүүнд нян судлалтын шинжилгээ хийх түргэвчилсэн шинжилгээний төхөөрөмж" нийлүүлэх гэрээг 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр "Лайфтроник" компанитай 466.4 сая		
--	--	--	--	--	--	--	--

					төгрөгөөр байгуулсан. Гэрээний дагуу тоног төхөөрөмжийг 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн дотор хүлээлгэн өгсөн. Лабораторийн тоног төхөөрөмжийн суурилуулалт, туршилт тохируулгын ажил хийгдэж байна. Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Гаалийн ерөнхий газрын хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд 11,270.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас Төрийн худалдан авах ажиллагааны газраас ирүүлсэн гэрээ байгуулах зөвлөмжийн дагуу 7 төсөл, арга хэмжээний гэрээг хуулийн хугацаанд багтаан 100 хувь байгуулсан. 1 төсөл, арга хэмжээ нь 05 сарын 31-ны дотор гэрээ байгуулах зөвлөмж нь ирээгүй тул 540 сая төгрөгийн төсөв Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн хэмнэлтэд тооцогдсон болно.		
					Гаалийн ерөнхий газрын урсгал төсвөөр 2025 онд нээлттэй 5, харьцуулалтын аргаар 3, нийт 8 тендер зарлахаар төлөвлөсөн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. Мөн ерөнхий гэрээгээр 4 худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Үүнд: 1. Нээлттэй тендер шалгаруулалт: 1.1. "Гаалийн байгууллагын албаны эрэлч нохойд зориулалтын хоол" нийлүүлэх 130 сая төгрөгийн төсөвтэй төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж "Аз болор мөнх трейд"		

					ХХК-тай 2025.03.14-нд 128.9 сая төгрөгөөр гэрээ байгуулж, гэрээний дагуу 2025.04.07-ны өдөр нохойн хоолыг хүлээн авч гэрээг дүгнэсэн. 1.2. "Харуул хамгаалалт үйлчилгээ үзүүлэх" 135 сая төгрөгийн төсөвтэй төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж "Шүтээн-Уул" ХХК-тай 2025.03.13-нд 134.7 сая төгрөгөөр гэрээ байгуулсан. Гэрээний дагуу ГЕГ, ГТЛ-ийн харуул хамгаалалт үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд гэрээг 2025.12.31-ны дотор дүгнэнэ. 1.3. "Гаалийн улсын байцаагчдын дүрэмт хувцас, дагалдах хэрэгсэл нийлүүлэх" Гаалийн байгууллагын 2025 онд санхүүжүүлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 2,000.0 сая төгрөг төлөвлөгдсөн. Гаалийн улсын байцаагчдын дүрэмт хувцас дагалдах хэрэгслийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах Үнэлгээний хороог Гаалийн ерөнхий газрын даргын 2025.01.14-ний өдрийн А/08 дүгээр тушаалаар байгуулсан. Үнэлгээний хороо тендерийн баримт бичиг боловсруулан ГЕГ/20250102008 дугаартай нээлттэй тендерийг 4 багцтайгаар зарласан. Багцууд: 1.3.1. Багц-1. Албаны костюм- 665,750,000 1.3.2. Багц-2. Албаны сорочкан цамц- 486,000,000 1.3.3. Багц-3. Хавар намрын ажлын хувцас- 308,250,000		
--	--	--	--	--	--	--	--

					1.3.4. Багц-4. Өвлийн хүрэм, өмд 540,000,000 2025.03.11-ний өдөр tender.gov.mn-д байршуулж 2025.04.09-нд нээсэн. Багц-1-/Албаны костюм/, Багц-2-/Албаны сорочкан цамц/-уудыг дахин зарлан 2025.06.09-ний өдөр нээж Багц-1-д Мастер тэйлоринг ХХК, Багц-2-д Батзүү ХХК, Блү клотинг студио ХХК, Урбан жийнс ХХК-ууд тендерийн баримт бичиг, дээж загвар ирүүлээд байна. 1.4. “Даатгалын үйлчилгээ” үзүүлэх 440.0 сая төгрөгийн төсөвтэй төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж “Хаан даатгал” ХХК-тай 2025.04.21-нд 342.3 сая төгрөгөөр гэрээ байгуулсан. Гэрээний дагуу гаалийн байгууллагын бүх албан хаагчид даатгалд хамрагдсан бөгөөд гэрээг 2025.12.31-ны дотор дүгнэнэ. 1.5. “Лабораторийн зориулалттай тоног хэрэгсэл болон урвалж бодис, стандарт дээж” нийлүүлэх 716.6 сая төгрөгийн төсөвтэй төсөл, арга хэмжээний 15 багц тендер шалгаруулалтыг зохион байгуулж байгуулж байгаа бөгөөд 2025.06.17-нд тендерийг нээхээр байна. 2. Харьцуулалтын арга: 2.1. “Бага үнэтэй түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс” нийлүүлэх 40 сая төгрөгийн төсөвтэй төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж “Фленти трейд” ХХК-тай 2025.02.18-нд 35.8 сая төгрөгөөр гэрээ байгуулсан. Гэрээний дагуу тухай бүр хэрэгцээт		
--	--	--	--	--	---	--	--

					бараа материалыг худалдан авч байгаа бөгөөд гэрээг 2025.12.31-ны дотор дүгнэнэ. 2.2. “Шатахуун нийлүүлэх” нийлүүлэх 50 сая төгрөгийн төсөвтэй төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж “Петростар” ХХК-тай 2025.03.10-нд 47.6 сая төгрөгөөр гэрээ байгуулсан. Гэрээний дагуу тухай бүр шатахуун худалдан авч байгаа бөгөөд гэрээг 2025.12.31-ны дотор дүгнэнэ. 2.3. “Принтерийн хор (бичиг хэрэг)” нийлүүлэх 27.4 сая төгрөгийн төсөвтэй төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж “Микросити” ХХК-тай 2025.04.24-нд 16.5 сая төгрөгөөр гэрээ байгуулсан. Гэрээний дагуу тухай бүр хэрэгцээт бараа материалыг худалдан авч байгаа бөгөөд гэрээг 2025.12.31-ны дотор дүгнэнэ. 3. Ерөнхий гэрээ: 3.1. “Гаалийн хяналт, шалгалтын нэг удаагийн троссон ломбо нийлүүлэх” 462.4 сая төгрөг - Эхлэл ургац ХХК шалгарч 1,260,000 ширхэгийг 462.4 сая төгрөгөөр, нэг удаагийн троссон ногоон ломбо 100,000 ширхэгийг 36.7 сая төгрөгөөр худалдан авах ГЕГ/019/001 дугаартай гэрээг 2024.02.03-нд байгуулсан. Ногоон ломбо 100,000 ширхэг, улаан ломбо 880,000 ширхэгийг бараа хүлээлцсэн актаар хүлээн авч санхүүжилтийг олгоод байна. 3.2. “Гаалийн төв лабораторийн шинжээч нарын хор саармагжуулах бүтээгдэхүүн		
--	--	--	--	--	--	--	--

					(Элгэн тараг)-ийг 3.1 сая төгрөгөөр худалдан авсан. 3.3. Гаалийн төв лабораторийн шинжээч нарын хор саармагжуулах бүтээгдэхүүн (Сүү)-ийг 2.6 сая төгрөгөөр худалдан авсан. 3.4. Гаалийн төв лабораторийн шинжээч нарын хор саармагжуулах бүтээгдэхүүн (Луувангийн нухаш)-ийг 3.2 сая төгрөгөөр худалдан авсан.		
					2024 оны төсвийн тухай хуулиар батлагдсан тоног төхөөрөмж - 14,500.0 сая төгрөг /Барьцаа дансан байршуулсан/ ОХУ-ын “ИСБ.А” ХХК-тай 2019 онд байгуулсан №ISBA-14-10/2019 дугаартай “Хяналтын систем нийлүүлэх, угсрах болон шалгах ажил гүйцэтгэх” гэрээний дагуу Монгол улсын хилийн 11 боомтод 14 иж бүрдэл төхөөрөмж суурилуулахаар гэрээ байгуулсан. Шивээхүрэн боомтод эхнэ 1 иж бүрдэл болох ISBA-005 сериал дугаартай тоног төхөөрөмжийг 2022 оны 05 дугаар сард, 2023 онд ISBA-006 сериал дугаартай төхөөрөмжийг Замын-Үүд боомтод, ISBA-007 сериал дугаартай төхөөрөмжийг Боршоо боомтод, 2024 онд ISBA-008 сериал дугаартай төхөөрөмжийг Ховд аймгийн Булган дахь гаалийн газар, ISBA-009 сериал дугаартай төхөөрөмжийг Гашуунсухайт дахь гаалийн газарт нүүрсний гарцын экспорт талд суурилуулан хүлээлгэн өгөөд байсан. Гашуунсухайт дахь гаалийн газарт нүүрсний гарцын импорт талд ISBA-011 сериал дугаартай төхөөрөмжийг суурилуулан ашиглалтад оруулж 2025 оны 03 дугаар сарын	2025.01.01- 2025.06.10	90

					20-нд бүрэн ашиглалтад хүлээж авсан. Замын-Үүд боомтын ачаа тээврийн цогцолборын экспорт талд ISBA-010 сериал дугаартай төхөөрөмж суурилуулагдах ажил 2025 оны 06 сарын 10-нд хийгдэж дууссан бөгөөд туршилтын ажил явагдаж байна. ГЕГ-ын даргын 2023 оны А/38 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2025.06.16-аас ажиллаж хүлээн авах асуудлыг шийдвэрлэнэ.		
					Гаалийн байгууллагын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийг зохион байгуулах Үнэлгээний хороо байгуулах ГЕГ-ын даргын 2025 оны 8 тушаалыг батлуулж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.		
					Гаалийн байгууллагын 2025 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг Сангийн яамны PIMIS программд оруулан ТХААГ-аас зохион байгуулсан тендерийн гүйцэтгэгчтэй байгуулсан 6 компанийн гэрээг баталгаажуулан гүйцэтгэл гаргахад бэлэн болсон.		
2	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Төсвийн хэмнэлт, хувиар, Үүссэн өглөг, авлага, төгрөгөөр, Гэрээний биелэлтийн үнэлгээгээр		Эхний хагас жил: Өөрийн нэгжийн чиг үүргийн хүрээнд ГЕГ-ын даргын 2025 оны А/190 дүгээр тушаалын хавсралтад заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг	1. АНУ-ын Эрчим хүчний яамны "Цөмийн материалын хууль бус хөдөлгөөнийг илрүүлэх саатуулах төсөл"-өөс үнэ төлбөргүй, техникийн тусламжийн хүрээнд нийлүүлэгдэж буй \$22,447.20 (Хорин хоёр мянга дөрвөн зуун дөчин долоон ам.доллар хорин цент) үнэ бүхий тоног төхөөрөмжийг 2025.03.07-нд ирсэн бөгөөд гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэн хүлээн авсан. Тус тоног төхөөрөмжийг суурилуулах АНУ-ын төслийн мэргэжилтэнүүд 2025 оны 07 сард Монгол улсад ажиллана.	2025.01.01-2025.06.10	100

				тайлагнан ажилласан байна.	2. 3. Дархан-Уул аймаг дахь Гаалийн хяналтын лабораторийн барилга угсралтын ажлын тендерийг үнэлэх хурал 2025 оны 3-р сарын 13, 20-ны өдрүүдэд болж, оролцогч Метадакс Инженеринг болон Өгөөмөр шанд ХХК-ын түншлэл компанийг тендерт шалгаруулсан. Гүйцэтгэгч нь гаалийн хяналтын лабораторийн барилгыг 2025 оны 10 сарын 15-нд барьж дуусахаар төлөвлөгдсөн.		
3	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт.	Хэрэгжилт гүйцэтгэлээр		Эхний хагас жил: Нэгжийн чиг үүрэгт хамааралтай болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.	Цөмийн энергийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь заалт, МУ-ын Засгийн газрын 2022 оны 4 дүгээр тогтооллын хэрэгжилт: АНУ-ын Эрчим хүчний яамнаас хэрэгжүүлдэг “Цөмийн материалын хууль бус хөдөлгөөнийг илрүүлэх, саатуулах (NSDD)” төсөлтэй хамтран 2025 оны хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргасан. Үүнд: - Хилийн боомтуудад суурилуулсан 100 иж бүрдэл цацрагийн хяналтын төхөөрөмжийн 50 гаруй хувь нь ажиллахгүй эвдрэлтэй байгааг засварлаж, хэвийн ажиллагаанд оруулах асуудлыг төслийн зүгээс 2025 ондоо багтаан шийдвэрлэхээр болсон. - Монгол улсын хилээр нэвтэрч буй цөмийн материал, цацрагийн үүсгүүрийн мэдээллий ГЕГ дээр шууд хянах нөхцөлийг бүрдүүлэхээр 22.4 мянган ам.долларын үнэ бүхий тоног төхөөрөмжийг хүлээн авч суурилуулалтын ажлыг хийлгэхээр тохирсон. - Цацрагийн хяналтын төхөөрөмжийн хэвийн ажиллагааг шалгах, тохируулга баталгаажилт хийх зориулалт бүхий Cs-	2025.01.01- 2025.06.10	100

					137, Co-60, Am-Be зэрэг гамма болон нейтрон цацрагийн үүсгүүрийг ГЕГ-т ирүүлэхээр болсон.		
4	Нэгжийн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал.	Хэрэгжилт гүйцэтгэлээр		Эхний хагас жил: Өөрийн нэгжийн чиг үүргийн хүрээнд эрсдлийн удирдлагыг хэрэгжүүл ажилласан байна.	- Чингис Хаан ОУНБ дахь Гаалийн газрын эвдрэлтэй рентген тоног төхөөрөмжийн засварыг хийлгэх ажлыг Нүктег компанитай тохирч 2025 оны 03 сарын төсвийн хуваарьт төсвийг оруулан шууд худалдан авалт хийж, тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагаанд оруулсан. - Алтанбулаг боомтын бүтээн байгуулалтын ажил дуусаж байгаатай холбоотой тус боомтод суурилуулсан цацрагийн хяналтын төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагаанд оруулах шаардлагатай 3 ширхэг сэлбэг хэрэгслийг тухайн гаалийн газраас ирүүлсэн албан бичгийн дагуу олгосон.	2025.01.01-2025.06.10	100
5	Үүрэг даалгавар, зөвлөмжийн биелэлт.	Хэрэгжилт гүйцэтгэлээр		Эхний хагас жил: Нэгжийн чиг үүргийн хүрээнд өгөгдсөн үүрэг даалгавар, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.	- Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүрт нь биелүүллэн ажилласан. - Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын товч мэдээллийг гарган 2025.06.02 нд Сангийн яаманд хүргүүлсэн. 2024 онд худалдан авсан автомашин, тээврийн хэрэгслийн талаарх мэдээллийг бэлтгэн 2025.05.27-нд Сангийн яаманд хүргүүлсэн. - Худалдан авах ажиллгаатай холбоотой болон бусад чиг үүргийн дагуу ирүүлсэн 93 албан бичиг, дотоод зурвасаас 78 хугацаанд нь шийдвэрлэж 15 бичиг шийдвэрлэх шатандаа явж байна. - Худалдан авах ажиллгаатай холбоотой 18 албан бичгийг боловсруулан холбогдох аж ахуйн нэгж, байгууллагуудад, 15 дотоод зурвасыг ГЕГ-ын нэгжүүдэд хүргүүлсэн.	2025.01.01-2025.06.10	100

					Өөрийн хийж хэрэгжүүлсэн ажлын талаарх 7 хоног бүрийн тайланг гаргаж байсан.		
6	Ажлын цаг ашиглалт	Төсвийн хэмнэлт, хувиар, Үүссэн өглөг, авлага, төгрөгөөр, Гэрээний биелэлтийн үнэлгээгээр		Энхий хагас жил: Нэгжийн албан хаагчдын ажлын цаг ашиглалт 100 хувь байна.	2025 оны эхний хагас жилийн байдлаар албан томилолтоор Гашуунсухайт боомтод 5 өдөр, Удирдлагын академийн "Төрийн захиргааны ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц" сургалтад ажлын 3 өдөр, хувийн ажлаах гадаад улс руу аялахаар 1 өдрийн чөлөө авсан зэрэг нийт 9 өдрөөд бусад ажлын өдрүүдэд ажлын байран дээрээ ажилласан болно.	2025.01.01-2025.06.10	100

8	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт.	Хэрэгжилт гүйцэтгэлээр		Эхний хагас жил: Гаалийн байгууллагын 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Гаалийн байгууллагын 2025 оны Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө, Гаалийн байгууллагын 2025 оны Архивын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн нэгжид хамааралтай ажлуудыг төлөвлөгөөнд заасан хугацаанд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.	• 2024 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг 2025 оны 01 сард бөглөж баталгаажуулсан.	2025.01.01-2025.06.10	100
---	---	------------------------	--	--	--	-----------------------	-----

ХОЁР. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Хариуцсан ажлын чиг үүргийн хүрээнд богино			Мэргэжил, мэргэшлээ	1. Их засаг их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн “Эрх зүйн” 2.5 жилийн	2025.01.01-2025.06.10	100%

	хугацааны зорилтот сургалтанд хамрагдах		дээшлүүлэх сургалтуудад хамрагдсан байна. /I-IV улирал/	эчнээ ангид суралцаж байгаа бөгөөд 2025.06 сард 1 дүгээр курсээ амжилттай төгсөөд байна. 2. Удирдлагын академийн "ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АХЛАХ ТҮШМЭЛИЙН МЭРГЭШҮҮЛЭХ БАГЦ" сургалтад 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн хамрагдаж эхэлсэн бөгөөд сургалт 2025 оны 10 сарын сүүлээр дуусна. 3. Сангийн яамнаас зохион байгуулсан "Төсвийн хөрөнгө оруулалт" сэдэвт сургалтад 2025 оны 06 дугаар сарын 06-нд хамрагдсан. 4. Захиргаа улирдлагын газраас зохион байгуулсан мэдээллийн цагт оролцож, мэдээлэллүүд сонссон.		
--	---	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ
(Албан тушаал)

 / Б.БЯМБАЦОГТ/
(Нэр, гарын үсэг)

0
(Огноо)

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Б.БЯМБАЦОГТЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Санхүү, хөрөнгө оруулалтын газар

1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, үр дүн	60	10	70	
2.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	48	5	53	
3.	Хууль, тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт	60	10	70	
4.	Нэгжийн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	53	5	58	
5.	Үүрэг даалгаврын биелэлт	53	5	58	
6.	Ажлын цаг ашиглалт	60	10	70	
7.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	60	10	70	
Дундаж оноо:				64.8	

2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийг хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Хариуцсан ажлын чиг үүргийн хүрээнд богино хугацааны зорилтот сургалтад хамрагдах	15	15	
2.	Бие даан суралцах	15	15	
Дундаж оноо:				15

3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
1.	Хандлага, ёс зүй	2	3
		7	

2.	Асуудал шийдвэрлэх		5
3.	Хариуцлагатай байдал		7
4.	Дүн шинжилгээ хийх		5
5.	Ажлын цаг ашиглалт		7
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6	Мэргэжлийн ур чадвар 1.		7
Дундаж оноо:			6.33

4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

Д/д	Хандлага, ёс зүй, ур чадвар	Хамт олны үнэлгээ (0-8)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо: 8		

5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)	(70 хүртэлх оноо) 63.3
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	(15 хүртэлх оноо) 15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	(7 хүртэлх оноо) 6.33
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	(8 хүртэлх оноо) 8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(..... оноо)
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		94.2

Үнэлгээ өгсөн:

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
(албан тушаал)

Нэгжийн дарга

И.Д.Долгорсүрэн/
(албан хаагчийн нэр)

2025.06.10 (огноо)

Үнэлгээтэй танилцаж,

Төрийн жинхэнэ албан хаагч:

зөөшөөрсөн:

Гаалийн улсын байцаагч
(албан тушаал)

Б.Бямбацогт/
(албан хаагчийн нэр)

2025.06.10 (огноо)

Үнэлгээг хянасан :

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Дэд даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч

.....

(Г.Энхтайван)

2025.06.25.....

(огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн хэлтсийн


Гаалийн улсын ахлах байцаагч

.....

(Ө.Тэгшээ)

2025.06.25.....

(огноо)



Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч:

Гаалийн ерөнхий газрын дарга

(Р.Отгонжаргал)

2025.06.25.....

(огноо)